

Өвөрхангай аймаг Өлзийт сум, Илдэн бээлийн хүрээ “Өлзийт хүрээ” Ганданноровлин Сайнноён хан аймгийн Илдэн бээлийн хошуу нутаг буюу одоогийн Өвөрхангай аймгийн Өлзийт сумын нутагт сумын төвөөс зүүн хойш Горхон голын савд Сүмбэр уулын хойт биед энэ хүрээ суурьшиж байжээ. Илдэн бээлийн хүрээ буюу Ганданноровлин хийд үүсгэн байгуулагдсан тухай үндэсний төв архивын сан хөмрөгт сайн Ноён хан аймгийн Жюн вангийн зэрэг Илдэн засаг төрийн бэйл Норовжанцаны хошууны урьд тушаалын бэйл Пунцагдоржийн үед Чин улсын төр гэрэлтын наймдугаар /1828/ онд дээдийн түмэн өлзийг бататгах хийгээд шашин амьтны тусын тулд Чогчин ном хуруулах лам нарыг суулгах нэгэн хэсэг бий болжээ. Борхошууны 1-р баг нь Сангийн далай нуур нь Улаанбаатар хотоос 370 км, аймгийн төв Арвайхээр хотоос 65км зайд орших ба Монгол орны төвийн хэсгээр нүүдэллэх нүүдлийн шувуудын цугладаг томоохон давст нуур юм. Түүх шашин соёл археологин дурсгалт газрууд нь Нэрт эрдэмтэн хэл шижлэлийн ухааны доктор /Ph.D/ Чой Лувсанжав. Соёлын гавьяат багш гавж Д.Цэрмаа тэргүүтэй олон сайхан эрдэмтэн мэргэд аварга малчид алдартнуудын өлзий нутаг.

- Нийт өрх 201 үүнээс малчин өрх 196.
- Нийт хүн ам 596 үүнээс малчин 393. Хүүхэд 198.
- Нийт мал 57902 Тэмээ 10, Адуу 5291, Үхэр 2509, Хонь 37143, Ямаа 12949.

Тус багийн төв нь 2018 онд 220квт сэргээгдэх эрчим хүчээр хангагдсан.

Мобикомын 4G сүлжээний станцууд 2020, 2022 онуудад тус тус ашиглалтанд орж дөрвөн сум болон багийн иргэд 2300 орчим өрх айл өргөн хэрэглээний сүлжээнд холбогдсон зэрэг онцлог давуу талуудтай.

2017 оноос хойш гаргасан амжилтуудаас

4 багаас малаараа удаа дараа тэргүүлж улсын аварга малчин 2, аймгийн болон сумын аваргуудаар бусад багуудаасаа болон хөрш зэргэлдээ сумуудаасаа байнга тэргүүлж явдаг аварга малчид олон бий